МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр Дугаар А/05 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Айл өрх, аж, ахуйн нэгж, байгууллагын хүрээнд зохион байгуулагдах "Дулаан байвал мянган лан" аяныг зохион байгуулах, дүгнэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Х.Даваасүрэн	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
П.Даваа-Очир	(Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын Өргөх механизмын хяналтын улсын байцаагч)
Н.Шинэбаяр	(Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын мэргэжилтэн)
Б.Аюуш	(Хөвгөл Эрчим хүч ХХК-ний Ашиглалтын албаны дарга)
Д.Өлзийням	(Хөвсгөл Дулааны станцын инженер)

Нарийн бичгийн дарга:

Д.Аюушжав	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

2. Дулаан байвал мянган лан" аяныг зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө боловсруулан батлуулах, иргэдийг мэдээ мэдээллээр хангаж, хэрэгжилтийн үр дүнг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны дотор тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712011363